



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/564

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIV хуралдааны 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон тодотголд газар эзэмших хүсэлт ирүүлж батлагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 6 иргэний нийт 0.2185 га (2185 м²) газрыг хавсралтад дурдсанаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 06-ны өдрийн
А/564 дугаар захирамжийн хавсралт

ШИНЭЭР ГАЗАР ЭЗЭМШИХ ИРГЭДИЙН ЖАГСАЛТ

№	Иргэний овог, нэр, регистр	Төлөвлөгөөний нэгж талбарын дугаар	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа	Тайлбар
1	Хайрхан овгийн Алтанцэцэг Бямбахишиг (РЛ83123002)	3061554	13-р баг	1256	Гэр, орон сууцны хашааны газар	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
2	Боржигон овгийн Түмэн-Өлзий Бат-Очир (РС62112614)	3268260	1-р баг	428	Гэр, орон сууцны хашааны газар	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
3	Боржигон овгийн Аюуш Энхболд (РФ71011070)	3092317	7-р баг	332	Гэр, орон сууцны хашааны газар	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
4	Хиад боржигон овгийн Лхачинжав Оргил (РЮ85112217)	3070406	8-р баг	44	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
5	Загдсамбар овгийн Ганболд Мөнхцэцэг (ХО71010801)	3090569	8-р баг	38	Автомашин гараж	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших

[Signature]

6	Шуудай овгийн Ренчиндорж Эрдэнэчулуун (ру86033119)	3092300	7-р баг	87	Автомашин засвар, үйлчилгээний газар	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
---	---	---------	---------	----	---	----	---

Нийт талбайн хэмжээ: 2185м²

-----000-----

